



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.9.8 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын 1.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөгөөнд тусгагдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулахыг хариуцан болон хамтран хэрэгжүүлэх байгууллагуудад үүрэг болгосугай.

3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Ганцэцэг)-т даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын алба (Г.Банзрагч)-нд үүрэг болгосугай.

ДАРГА



ДЭМХ-АМГАЛАН

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн  
2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн  
09 дүгээр тогтоолын хавсралт

1119276367  
5284708 СБА1473




ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС  
САНХҮҮЖҮҮЛЭХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 11 дүгээр сарын 08

Улаанбаатар хот


№	Гүйцэтгэх ажлын чиглэл	д/д	Арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа
1	2	3	4	5	6	7
I	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хороо, салбар хороо, зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, гишүүдийг чадавхжуулах чиглэлээр	1	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Нийслэлийн ХАБЭА-н зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах;	МАОЭНХ	НЗДТГ НАОЭНХ НҮЭХ	XI сар
II		2	“Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2023” болзолт уралдааныг зохион байгуулах;	ХАБЭМТ	ГБХНХЯ ХАБЭА-н Үндэсний хороо	XI сар
		3	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2024”-ыг зохион байгуулах;	ХАБЭМТ	ГБХНХЯ ХАБЭА-н Үндэсний хороо	XI сар

	Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр	4	Нэхмэл эдлэл, хувцас, арьс, гутал зэрэг хөнгөн үйлдвэрлэлийн ХАБЭА-н үйл ажиллагааны олон улсын дүрэм, стандартаар компанийт ажил, контент, зурагт хуудас бэлтгэж хэвлүүлэх, олон нийтэд түгээх;	MХҮАҮХ	МҮЭХ	
	Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр	5	Малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор малчдад зориулсан сурталчилгааны материал бэлтгэх, түгээх;	НДЕГ	НДЕГ	XI cap
II	Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр	6	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчиний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг Монгол Улсын топ 100 аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах;	МАОЭНХ	Дүүргийн АОЭХ	XI cap
	Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр	7	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчиний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг Архангай, Өвөрхангай аймгуудад сурталчлах;	МАОЭНХ	Аймгийн АОЭХ	XI cap
	Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр	8	Барилгын салбарын ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 11 төрлийн зааварчилгааг боловсруулах, өдөр тутмын зааварчилгааны дэвтрийг шинэчлэн хэвлүүлж, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан түгээх;	Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургууль	Барилгын хөгжлийн төв	XI cap
	Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр	9	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ISO:45001 стандартыг сурталчлах видео контент бэлтгэж, түгээх;	МАОЭНХ	Ололт амжилт ХАБЭА-н сургалтын төв	XI cap
	Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр	10	"Ажил мэргэжлийн ангилал, жагсаалт, кодчилол" ном хэвлүүлэх;	Монголын ХАБЭА-н мэргэшсэн ажилтны үндэсний нийгэмлэг НҮТББ	ГБХНХЯ	XI cap



III	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэг судалгаа, үнэлгээ хийх бодлого, стандартыг боловсронгуй болгох чиглэлээр	11	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	МАОЭНХ	"Алтан дуулга" ТББ 1119276367 5284706 СБА1473	XI сар
		12	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилгааг зохион байгуулах үндсэн дүрмийг боловсруулах;	МАОЭНХ	"Алтан дуулга" ТББ	XI сар
		13	Албан бус салбарын ажилчдын мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах;	МХЭАҮХ	ГБХНХЯ АШУУИС	XI сар
		14	Хөдөлмөрийн эрүүл ахуйн үндэсний стандартын үзлэг зохион байгуулж, шинэчлэх, шинээр боловсруулах стандартыг мөрдүүлэх төлөвлөгөө гаргаж, зөвлөмж боловсруулах;	МХЭАҮХ	ГБХНХЯ СХЗГ	XI сар
		15	Нийгмийн даатгалын үндсэн платформд веб сайт интеграци хийх;	ГБХНХЯ	НДЕГ	XI-XII сар
		16	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн урт хугацааны тооцоолол хийх;	ГБХНХЯ	НДЕГ	XI-XII сар
		17	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн систем (om.inspection.gov.mn)-ийн хөгжүүлэлт, мобайл хөгжүүлэлт, мэдээлэл солилцох цахим систем холболт;	ГБХНХЯ	ХХҮЕГ	XI-XII сар
		18	Нэгдсэн үндэстний байгууллагатай хамтран "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам" сэдэвт хурал зохион байгуулах;	ГБХНХЯ	ГБХНХЯ	XII сар
		19	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийн конвенцыг сурталчлах ажлыг зохион байгуулах, гарын авлага боловсруулж, хэвлүүлэх, түгээх;	ГБХНХЯ	ХАБЭМТ	XI сар

IV	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар сургалтын материал бэлтгэн, сургалт зохион байгуулах чиглэлээр	20	Нийслэлийн дүүргүүдийн жижиг, дунд үйлдвэрт ажиллагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, тогтоомж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчинөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	НДЕГ	НДЕГ Дүүргийн Нийгмийн даатгалын газрууд	XI сар
IV	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар сургалтын материал бэлтгэн, сургалт зохион байгуулах чиглэлээр	21	"Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил", "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчинөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах;	НДЕГ	НДЕГ Аймгийн Нийгмийн даатгалын газрууд	XI сар
IV	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар сургалтын материал бэлтгэн, сургалт зохион байгуулах чиглэлээр	22	Хамгаалах хэрэгслийн туршилтын лабораторийн тоног төхөөрөмжийн бүтэц, үйл ажиллагааг таниулах, туршилт хийх арга зүйн сургалтад мэргэжилтнуудийг хамруулах;	ХАБЭМТ	ГБХНХЯ Ньюбогат ХХК	XI сар
IV	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар сургалтын материал бэлтгэн, сургалт зохион байгуулах чиглэлээр	23	Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтнуудад асbestosийн хор нөлөөг сурталчлан таниулах сургалт зохион байгуулах;	ХАБЭМТ	ГБХНХЯ ЭХЯ	XI сар
		24	Улаанбаатар хотын орон сууц, нийтийн аж ахуйн салбарын ХАБЭА-н ажилтнуудад чадавхжуулах сургалт зохион байгуулах;	МОСЧААЯА-ны ҮЭ-ийн холбоо	Арш хур ХАБЭА-н сургалтын төв	XI сар
		25	Эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудыг мэргэжлээс шалтгаалсан өвчинөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр сургалт зохион байгуулах, зурагт хуудас, гарын авлага бэлтгэх, тараах;	Эрүүл мэндийн ажилтнуудын ҮЭ-ийн холбоо	МҮЭХ	XI сар



	26	"Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний арга зүйн шинэчлэл" сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/155 дугаар тушаал, MNS 5080:2023 стандартын дагуу итгэмжлэлийн үнэлгээний мэргэжилтэн, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний мэргэжилтэн нарт зохион байгуулах;	МХЭАҮХ	ГБХНХЯ ХАБЭМТ Үндэсний итгэмжлэлийн төв	XI сар
	27	Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын шилдэг 2 аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран "Эрүүл, аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага" дадлага сургалтыг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтнуудад зохион байгуулах.	ГБХНХЯ-ны СХГ ГБХНХЯ-ны ХАБЭАХХ	ХХҮЕГ	XI сар

---Оо---

